



Говь-Алтай аймаг дахь  
Төрийн аудитын газар

# НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ, ТҮҮНД  
ТАВИХ ХЯНАЛТ СУЛ БАЙНА.

“ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”-Д ХИЙСЭН  
НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ЭУГ-2025/21-ШТА-НА

Алтай хот 2025 он



Газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа  
Утас: 70483413 Цахим хаяг: [gunjidmaag@audit.gov.mn](mailto:gunjidmaag@audit.gov.mn)  
Аудитын менежер Д.Эрдэнэчимэг  
Утас: 70483413 Цахим хаяг: [erdenechimegd@audit.gov.mn](mailto:erdenechimegd@audit.gov.mn)  
Аудитор Ц.Сайханжаргал  
Утас: 70483413 Цахим хаяг: [saikhanjargalts@audit.gov.mn](mailto:saikhanjargalts@audit.gov.mn)  
Аудитор Г.Энхдэлгэр  
Утас: 70483413 Цахим хаяг: [enkhdelgerg@audit.gov.mn](mailto:enkhdelgerg@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах  
хаягаар авна уу.



**АГУУЛГА**

<b>ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ</b> .....	3
<b>ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ</b> .....	3
<b>АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ</b> .....	4
<b>ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ</b> .....	5
<b>БҮЛЭГ 1. ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХГҮЙ БАЙНА.</b> .....	5
Орон тоо илүү ажиллуулах, тэтгэмж давхардуулан олгох, хуулиар зөвшөөрөөгүй зардал гаргах зөрчил давтагдан гарсаар байна. ....	5
Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр шагнал урамшуулал, дэмжлэг олгох, бэлэг дурсгалын зүйл худалдах авах зөрчил жил бүр давтагдан гарч байна. ....	9
<b>БҮЛЭГ 2. АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНААР ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БАТАЛСААР БАЙНА.</b> .....	12
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023-2024 онд ТЭЗҮ хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй 7, орон нутгийн хөгжлийн сангаас 296 төсөл, арга хэмжээг баталжээ. ....	12
Цахим худалдан авах ажиллагааг хуульд заасан журмын дагуу зохион байгуулахгүй байна.....	14
<b>БҮЛЭГ 3. ТӨРИЙН САНГИЙН НЭГДСЭН СИСТЕМЭЭР ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛСНААР ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАГДАХААР БАЙНА.</b> .....	15
Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн зөрчил давтан гарсаар байна. ....	15
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлснээр 2022-2024 онуудад байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын хүрээнд 3,093.0 сая төгрөгийн хэмнэлт бий болсон байна.....	16
Албан тушаалтны хариуцлагагүй байдлаас шалтгаалан Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулахгүй байгаа зөрчил давтан гарсаар байна. .	19
<b>ДҮГНЭЛТ:</b> .....	21
<b>ШИЙДВЭР:</b> .....	21



## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НА	Нийцлийн аудит
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ШТА	Шууд тайлагнах аудит
ЭУГ	Эрсдэлийн удирдлагын газар
ЭХС	Эрчим хүчний систем

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Хуулийн 12 дугаар зүйлийг зөрчсөн зөрчлийн дүн.	8
Хүснэгт 2	Хуулийн 15.1 дэх хэсгийн зөрчлийн дүн	9
Хүснэгт 3	Хуулийн 15.2 дахь хэсгийг зөрчсөн зөрчлийн дүн	11
Хүснэгт 4	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчил	15
Хүснэгт 5	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын төсвийн хэмнэлт.	17
Хүснэгт 6	Улсын төсвийн байгууллагуудын төсвийн хэмнэлт.	18
Хүснэгт 7	Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн цэвэр ашиг	18



## АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

<p>Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх</p>	<p>Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2024 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаалыг үндэслэн гүйцэтгэлээ.</p>
<p>Аудитын зорилго</p>	<p>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд нийцлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>● Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажилласан уу?</li> <li>● Хөрөнгө оруулалттай холбоотой хуульд заасан журмыг хэрэгжүүлж ажилласан уу?</li> <li>● Засаг газар болон төрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байсан уу?</li> </ul>
<p>Аудитын хамарсан хүрээ</p>	<p>Аудитад Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, төсвийн байгууллагууд, зарим төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2022-2024 оны санхүүгийн тайланг хамруулан аудитын хийж гүйцэтгэлээ. Хууль, хяналтын байгууллага болон шүүхээр хянан хэлэлцэж буй асуудлыг аудитад хамруулаагүй болно.</p>
<p>Аудитын арга зүй</p>	<p>Аудитыг аудитын гүйцэтгэлийн стандарт АДБОУС 100, 400, 4000-4200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-4:2020, “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020, “Нийцлийн аудитын стандарт” MNS 6817-8:2020, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, судалгаа авах, ярилцлага хийх арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.</p>
<p>Аудитын шалгуур үзүүлэлт</p>	<p>Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүйтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.</p> <ul style="list-style-type: none"> <li>● Төсвийн тухай хууль</li> <li>● Төрийн хэмнэлтийн тухай хууль</li> </ul>



Аудитын баг,  
бүрэлдэхүүн

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
  - Холбогдох бусад хууль тогтоомж эрх зүйн актууд
- Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа удирдаж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Ц.Сайханжаргал, Г.Энхдэлгэр нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 онд 4 бүлэг 22 зүйл заалттай батлагдаж, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн байна. Хуульд 2022 онд 1 удаа, 2023 онд 2 удаа, 2024 онд 3 удаа тус тус нэмэлт өөрчлөлт оруулж баталсан.

Аудитад Говь-Алтай аймагт үйл ажиллагаа явуулж буй 206 төрийн байгууллага, тусгай сан, төрийн болон орон нутгийн хуулийн этгээдийг хамрууллаа.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2022 оны А/59 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”, 2022 оны А/89 дүгээр тушаалаар баталсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-т зохих өөрчлөлтийг тусгасан бөгөөд 2022, 2023, 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит гүйцэтгэхдээ горим, сорил хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газраас хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар 2022 оны 1,041.7 сая төгрөгийн 357, 2023 оны 866.9 сая төгрөгийн 57, 2024 оны 2,953.5 сая төгрөгийн 259 зөрчил илрүүлэн 36.4 сая төгрөгийн 5 зөрчлийг залруулах, 533.8 сая төгрөгийн 173 зөрчилд төлбөрийн акт, 4,256.5 сая төгрөгийн 415 зөрчилд албан шаардлага, 35.4 сая төгрөгийн 80 зөрчилд зөвлөмж хүргүүлжээ.

## БҮЛЭГ 1. ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХГҮЙ БАЙНА.

**Орон тоо илүү ажиллуулах, тэтгэмж давхардуулан олгох, хуулиар зөвшөөрөөгүй зардал гаргах зөрчил давтагдан гарсаар байна.**

1.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хуульд тусгайлан заагаагүй бол төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн этгээд тэргүүн дэд, дэд, орлогч, зөвлөхтэй байхыг хориглосон.<sup>1</sup>

<sup>1</sup> 5.1.Хуульд тусгайлан заагаагүй бол төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг Засгийн газрын агентлаг, Засгийн газрын ажлын алба, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага, эмнэлэг, төрийн болон орон нутгийн өмчийн их сургууль, төрийн өмчийн оролцоотой нээлттэй хувьцаат компаниас бусад этгээд тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглоно.

*/Энэ хэсэгт 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./*



Төрийн аудитын байгууллагаас хуулийн 5 дугаар зүйлд заасан хязгаарлалтыг хэрэгжүүлээгүй 2022 оны 16.9 сая төгрөгийн 2, 2023 оны 6.2 сая төгрөгийн 1, 2024 онд 87.3 сая төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, 1 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

- 1.2. Шалгагдагч этгээдээс 2023-2024 онд өгсөн дээрх аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

**Аудитын илрүүлэлт**

- Аймгийн ЗДТГ нь аймгийн Засаг даргын орлогч илүү ажиллуулан 2022 онд 10.9 сая төгрөг, 2024 онд 10.5 сая төгрөгийн цалин хөлс олгосон;
- Аймгийн ЗДТГ нь орон тооны аймгийн Засаг даргын зөвлөх ажиллуулан 2022 онд 6.0 сая төгрөг, 2023 онд 6.2 сая төгрөгийн, 2024 онд 52.0 сая төгрөгийн цалин хөлс олгосон;
- Цогт сумын ЗДТГ нь 2024 онд сумын Засаг даргын орлогч 1-ээр илүү ажиллуулан 24.8 сая төгрөгийн цалин олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан.

- 1.3. Хуулийн 6 дугаар зүйл<sup>2</sup>-ийн хот дотор албан тушаалын автомашин ашиглахыг хориглосон заалтыг хэрэгжүүлээгүй 2022 оны 13.4 сая төгрөгийн 15, 2023 оны 0.6 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2022 оны 1, 2023 оны 0.9 сая төгрөгийн 1, 2024 оны 6.2 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага өгч, 2022 оны 72 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.

- 1.4. Хэрэгжилтийг авч үзвэл төлбөрийн акт, албан шаардлага бүрэн хэрэгжиж, зөвлөмжийн хэрэгжилт 48.8 хувьтай байна.

---

5.2. Нийслэлийн Засаг дарга хоёр, аймаг, дүүрэг, сумын Засаг дарга нэгээс илүү орлогч даргатай байхыг хориглоно.

5.3. Засгийн газрын агентлагийн дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны этгээд ажиллуулахыг хориглоно.

5.4. Энэ хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно.

<sup>2</sup> 6.1. Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно.

6.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, баг, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно.  
/Энэ хэсэгт 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

6.3. Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн автотээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно.

6.4. Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ.



- 1.5. Аймгийн хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй 722 тээврийн хэрэгслээс 51.2 хувь буюу 370 нь тод өнгийн дэвсгэр бүхий улсын дугаар ашиглаж байгаа бол 352 нь энгийн өнгө бүхий дугаартай байна.
- 1.6. Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан хот дотор албаны бус зориулалтаар автомашин ашиглахыг хориглохоор заасан боловч 21.2 сая төгрөгийн шатахууныг зарцуулсан байна.

**Аудитын илрүүлэлт**

- Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй 352 автотээврийн хэрэгсэл нь энгийн өнгө бүхий улсын дугаартай;

- 1.7. Говь-Алтай аймагт 2022-2024 онд захиргааны зориулалтаар шинээр барилга баригдаагүй байна.
- 1.8. Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг”<sup>3</sup>-ийг тогтоосон. Тус тогтоолыг шинэчлээгүй, хяналт-шинжилгээ хийсэн байдал тогтоогдохгүй байна.<sup>4</sup>
- 1.9. Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр 2024 онд 4 байгууллага нийт 12.0 сая төгрөгөөр бомбер, спортын хувцас худалдан авсан зөрчилд 2.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 9.5 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлагыг хүргүүлжээ.<sup>5</sup>

**Аудитын илрүүлэлт**

- Аймгийн ЗДТГ, Төгрөг сумын Соёлын төв, Чандмань сумын ЗДТГ, Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргаа нь 2024 онд 0.7-8.8 сая төгрөгөөр бомбер, дүрэмт хувцас худалдан авчээ.

- 1.10. Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчдад 2024 онд 4.0 сая төгрөгийн зардлыг 3 байгууллага давхардуулан олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.<sup>6</sup>

<sup>3</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=201941&showType=1>

<sup>4</sup> 7.3.Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, хэрэгслийн нийтлэг жишгийг Засгийн газар батална.

<sup>5</sup> 8.1.Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно.

<sup>6</sup> 9.3.Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно.



- 1.11. Харин агаарын тээврийн хэрэгслээр албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагч энгийн зэрэглэлээс бусад суудлаар зорчсон зөрчил илрээгүй байна.<sup>7</sup>

**Аудитын илрүүлэлт**

- *Есөнбулаг сумын 1 дүгээр цэцэрлэг, Эрдэнэ сумын ЗДТГ, Алтай-Улиастай ЭХС ТӨХК нь албан хаагчид томилолтын зардлыг 0.5-2.0 сая төгрөгөөр хэтрүүлэн олгожээ.*

- 1.12. Албан хаагчид тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж 36.4 сая төгрөгийг 2022 онд 5 байгууллага давхардуулан олгосон зөрчил илэрч, төлбөрийн акт тогтоосон байна.<sup>8</sup> Шийдвэрийн хэрэгжилт 62.0 хувьтай, хугацаа дууссан байна.

**Аудитын илрүүлэлт**

- *Тонхил сумын ЗДТГ, Цээл сумын ЗДТГ, Ус, цаг уур, орчны шинжилгээний газар, Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргаа, Ардын дуу бүжгийн Алтай чуулга 1.0-31.3 сая төгрөгийн тэтгэмжийг давхардуулан олгосон байна.*

- 1.13. Хуулийн 12 дугаар зүйлд<sup>9</sup> заасан бусад хангамжийн зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглох зохицуулалтын хүрээнд 2022 оны 0.3 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 2023 оны 0.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 125.7 сая төгрөгийн 10 зөрчилд албан шаардлага, 2024 оны 80.2 сая төгрөгийн 28 зөрчилд төлбөрийн акт, 1,105.2 сая төгрөгийн 43 зөрчилд албан шаардлага, 22.7 сая төгрөгийн 1 зөрчилд зөвлөмжийг хүргүүлсэн.

- 1.14. Хэрэгжилтийг авч үзэхэд 2023-2024 оны төлбөрийн актыг бүрэн барагдуулж, албан шаардлагын хэрэгжилт 90.0 хувьтай байна.

Хүснэгт №1. Хуулийн 12 дугаар зүйлийг зөрчсөн зөрчлийн дүн (сая төгрөг)

Д/д	Хуулийн заалт	2022 он		2023 он		2024 он		Нийт дүн	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн

<sup>7</sup> 9.1.Энэ хуулийн 3.1-д заасан этгээд агаарын тээврийн хэрэгслээр албан томилолтоор энгийн зэрэглэлээс бусад суудлаар төсвийн болон байгууллагын хөрөнгөөр зорчихыг хориглоно.

<sup>8</sup> 11.1.Төрийн албаны тухай хуулиас бусад хуульд албан хаагчид тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгохоор заасан бол албан хаагч тэдгээрээс аль илүүг сонгох эрхтэй бөгөөд давхардуулан олгохгүй.

<sup>9</sup> 12.1.Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно:

12.1.1.үндсэн үйл ажиллагаа нь шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй этгээдийн албаны гар утасны зардлаас бусад гар утасны зардал;

/Энэ заалтад 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

12.1.2.ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсхүл өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардал;

/Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./

12.1.3.хэвлэлийн захиалгын төлбөр;

12.1.4.хуулиар зөвшөөрөөгүй бусад.



1	12.1.1 <sup>10</sup>	1	0.3	0	0	0	0	1	0.3
2	12.1.2 <sup>11</sup>	0	0	0	0	0	0	0	0
3	12.1.3 <sup>12</sup>	0	0	0	0	1	5.0	1	5.0
4	12.1.4 <sup>13</sup>	0	0	11	126.0	71	1,203.0	82	1,329.0
<b>Нийт дүн</b>		<b>1</b>	<b>0.3</b>	<b>11</b>	<b>126.0</b>	<b>72</b>	<b>1,208.0</b>	<b>83</b>	<b>1,334.3</b>

Эх сурвалж: Санхүүгийн тайлангийн аудитын дүн.

- 1.15. Зөрчлийг авч үзэхэд төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь өөрт эрх олгоогүй, хуулиар зөвшөөрөөгүй зардлуудыг гаргасан байна.
- 1.16. Говь-Алтай аймгийн 16 сум 2024 онд 100 жилийн ой зохион байгуулсантай холбоотойгоор урлаг, соёлын арга хэмжээ, зочид төлөөлөгчдийн хоол хүнс, нутгийн зөвлөлийн уулзалт, хүлээн авалт зэрэг арга хэмжээнд хуульд заагаагүй зардал гаргасан нь тус онд зөрчил өсөх шалтгаан болжээ.

**Аудитын илрүүлэлт**

- Гар утасны зардал төсвөөс олгосон 0.3 сая төгрөгийн 1 зөрчил;
- Хэвлэл захиалгын төлбөр төсвөөс олгосон 5.0 сая төгрөгийн 1 зөрчил;
- Хуулиар зөвшөөрөөгүй бусад зардалд 1,329.0 сая төгрөгийн 82 зөрчил гаргасан байна.

**Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр шагнал урамшуулал, дэмжлэг олгох, бэлэг дурсгалын зүйл худалдах авах зөрчил жил бүр давтагдан гарч байна.**

- 1.17. Хэмнэлтийн бусад арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 2022 оны 920.9 сая төгрөгийн 259, 2023 оны 406.7 сая төгрөгийн 25, 2024 оны 983.6 сая төгрөгийн 117 зөрчил илрүүлэн, 319.1 сая төгрөгийн 114 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,983.3 сая төгрөгийн 282 зөрчилд албан шаардлага, 8.8 сая төгрөгийн 6 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

Хүснэгт №2. Хуулийн 15.1 дэх хэсгийн зөрчлийн дүн (сая төгрөг)

Д/д	Хуулийн заалт	2022 он		2023 он		2024 он		Нийт дүн	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	15.1.1 <sup>14</sup>	0	0	0	0	0	0	0	0

<sup>10</sup> 12.1.1.үндсэн үйл ажиллагаа нь шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй этгээдийн албаны гар утасны зардлаас бусад гар утасны зардал;

<sup>11</sup> 12.1.2.ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсхүл өөрийн болон эхнэр/нөхөр/-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардал;

<sup>12</sup> 12.1.3.хэвлэлийн захиалгын төлбөр;

<sup>13</sup> 12.1.4.хуулиар зөвшөөрөөгүй бусад.

<sup>14</sup> 15.1.1.Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэргүйгээр шинээр хараат болон охин компани байгуулах;



2	15.1.2 <sup>15</sup>	0	0	0	0	0	0	0	0
3	15.1.3 <sup>16</sup>	111	712.3	15	259.1	78	344.7	204	1,316.1
4	15.1.4 <sup>17</sup>	0	0	0	0	0	0	0	0
5	15.1.5 <sup>18</sup>	0	0	7	134.8	18	244.5	25	379.3
6	15.1.6 <sup>19</sup>	6	34.1	2	13.0	0	0	8	47.1
7	15.1.7 <sup>20</sup>	0	0	0	0	0	0	0	0
<b>Нийт дүн</b>		<b>117</b>	<b>746.4</b>	<b>24</b>	<b>406.9</b>	<b>96</b>	<b>589.1</b>	<b>237</b>	<b>1,742.3</b>

Эх сурвалж: Санхүүгийн тайлангийн аудитын дүн.

- 1.18. Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгож буй зөрчил өссөн шалтгаан нь Засаг даргын нөөц хөрөнгөнөөс шагнал, дэмжлэг, урамшууллын зардал гаргасан, санхүүгийн ажилтанд урамшууллыг албан тушаалын үндсэн цалингийн 150.0 хувиас дээш хувиар олгосон, эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй, сахилгын шийтгэлтэй албан хаагчид улирлын ажлын урамшуулал олгож байгаатай холбоотой байна.
- 1.19. Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах зөрчил нь аймаг, сумын аварга шалгаруулах, түүхт 100 жилийн ойн арга хэмжээг 2023 он, 2024 онд зохион байгуулсантай холбоотойгоор өссөн. Тус зардлыг ихэвчлэн Засаг даргын нөөц хөрөнгийн төсвөөс санхүүжүүлсэн байна.
- 1.20. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль<sup>21</sup>, Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам”<sup>22</sup>-д заасан түүхэн үйл явдлыг тэмдэглэн өнгөрүүлэхэд улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх, ойг тэмдэглэх ажлын хүрээнд зохион байгуулах арга хэмжээ, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт,

<sup>15</sup> 15.1.2.чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох;

<sup>16</sup> 15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;

<sup>17</sup> 15.1.4.Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх;

<sup>18</sup> 15.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;

<sup>19</sup> 15.1.6.нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;

<sup>20</sup> 15.1.7.байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах.

<sup>21</sup> <https://legalinfo.mn/mn/detail/399>

<sup>22</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=209833&showType=1>



зарцуулалтын нийтлэг журам<sup>23</sup>-ын 2 дугаар зүйлийн 2.1.4<sup>24</sup>, 2.1.5<sup>25</sup>, 2.1.6<sup>26</sup> дахь заалтын дагуу тус сангаас иргэдэд хүсэлтийн дагуу дэмжлэг, нэг удаагийн буцалтгүй тусламж олгох, сайн малчны шагнал олгох зэрэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.4, 15.1.5 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

1.21. Иймд Төрийн хэмнэлтийн тухай хуульд хууль тогтоомж, тогтоол, журмын хоорондын уялдааг хангасан, илүү нарийвчилсан зохицуулалтуудыг тусгах шаардлагатай байна.

Хүснэгт №3. Хуулийн 15.2 дахь хэсгийг зөрчсөн зөрчлийн дүн (сая төгрөг)

Д/д	Хуулийн заалт	2022 он		2023 он		2024 он		Нийт дүн	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	15.2.1 <sup>27</sup>	24	56.3	0	0	0	0	24	56.3
2	15.2.2 <sup>28</sup>	53	0	0	0	0	0	53	0
3	15.2.3 <sup>29</sup>	0	0	0	0	0	0	0	0
4	15.2.4 <sup>30</sup>	65	114.9	0	0	0	0	65	114.9
5	15.2.5 <sup>31</sup>	1	3.3	0	0	15	346.2	16	349.5
6	15.2.6 <sup>32</sup>	0	0	1	0	6	48.2	1	48.2
<b>Нийт дүн</b>		<b>143</b>	<b>174.5</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>21</b>	<b>394.4</b>	<b>165</b>	<b>568.9</b>

Эх сурвалж: Санхүүгийн тайлангийн аудитын дүн

1.22. Шийдвэрийн хэрэгжилтийн хувьд 2022 оны төлбөрийн актын хэрэгжилт 68.0 хувь, албан шаардлагын хэрэгжилт 49.0 хувь, зөвлөмжийг бүрэн

<sup>23</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16207246587961>

<sup>24</sup> 2.1.4. байгууллага, иргэдээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэх;

<sup>25</sup> 2.1.5. энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ;

<sup>26</sup> 2.1.6. шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг.

<sup>27</sup> 15.2.1.байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

<sup>28</sup> 15.2.2.нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах;

<sup>29</sup> 15.2.3.сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;  
*/Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./*

<sup>30</sup> 15.2.4.цахим гарын үсэг, цахим шуудан ашиглах зэргээр албан бичиг боловсруулах, илгээх үйл явцыг хялбаршуулж бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хор, шуудан хүргэлтийн зардлыг хэмнэх;  
*/Энэ заалтыг 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./*

<sup>31</sup> 15.2.5.хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх;

<sup>32</sup> 15.2.6.байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох.



хэрэгжүүлсэн бол 2023 оны төлбөрийн актыг бүрэн барагдуулж, албан шаардлагыг 73.0 хувьтай хэрэгжүүлсэн байна.

- 1.23. Засаг даргын нөөц хөрөнгөнөөс иргэдэд дэмжлэг, шагнал урамшуулал олгосон зөрчилд өгсөн шийдвэрүүд хэрэгжээгүй байна.
- 1.24. Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т заасны дагуу нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг дулааны тоолууртай болгох тухай албан шаардлагыг 2023 онд Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газраас 53 шалгагдагч байгууллагуудад хүргүүлсэн.
- 1.25. Дулааны эрчим хүчээр хангагч байгууллагууд Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс үнэ тариф тогтоох зөвшөөрөл аваагүй гэх шалтгаанаар техникийн нөхцөл олгохгүй байгаа тул шийдвэр хэрэгжээгүй болно.
- 1.26. Говь-Алтай аймагт төрийн өмчит 5, орон нутгийн өмчит 8 хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөл, аймгийн Засаг дарга болон гүйцэтгэх захирлын хооронд байгуулах гэрээг нэг жилийн хугацаатай байгуулж, дүгнэж ажилласан байна.

#### **Аудитын илрүүлэлт**

- Хууль тогтоомжид зааснаар өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгосон 1,316.0 сая төгрөгийн 204 зөрчил;
- Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан 379.0 сая төгрөгийн 25 зөрчил;
- Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцөлсөн 47.1 сая төгрөгийн 8 зөрчил;
- Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэж ажиллаагүй 56.3 сая төгрөгийн 24 зөрчил;
- Нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглалттай холбоотой 53 зөрчил;
- Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэж ажиллаагүй 114.9 сая төгрөгийн 65 зөрчил ;
- Хуваарьт болон хугацаа этгэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлээгүй 34.5 сая төгрөгийн 16 зөрчил;
- Байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгохтой холбоотой 48.2 сая төгрөгийн 1 зөрчил тус тус илэрсэн байна.

## **БҮЛЭГ 2. АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНААР ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БАТАЛСААР БАЙНА.**

**Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023-2024 онд ТЭЗҮ хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй 7, орон нутгийн хөгжлийн сангаас 296 төсөл, арга хэмжээг баталжээ.**




- 2.1. Хуулийн 13.1.1, 13.1.2 дахь заалтыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан тул аудитад хамруулан үзсэнгүй.<sup>33</sup>
- 2.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд 1,213.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр 20 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас 575.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 төсөл, арга хэмжээг ТЭЗҮ, зураг төсөв, ажлын даалгаваргүйгээр аймгийн ИТХ-аар баталсан байна.
- 2.3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд 4,008.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 19 төсөл, арга хэмжээг 2,083.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр, 50.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл, арга хэмжээг ТЭЗҮ, зураг төсөв, ажлын даалгаваргүйгээр аймгийн ИТХ-аар баталсан байна.
- 2.4. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжих 3,720.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2,620.5 сая төгрөгөөр санхүүжих дүнтэй 8 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зарлаж шалгарсан оролцогчтой 3,612.9 сая төгрөгийн гэрээ байгуулах эрх олгож, тендерээс 107.4 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна.
- 2.5. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т<sup>34</sup> заасан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхийг хориглосон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн зөрчил илрээгүй байна.
- 2.6. Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны эх үүсвэрээр 19,460.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 614 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймаг, сумдын ИТХ-аар баталснаас 16,398.3 сая төгрөгийн 493 ажлыг санхүүжүүлснээс 24.1 хувь буюу 4,024.9 сая төгрөгийн 148 төсөл, арга хэмжээнд иргэд олон нийтээс санал аваагүй.<sup>35</sup>
- 2.7. Нийт төсөл, арга хэмжээний 48.0 хувь 4,622.5 сая төгрөгийн 296 төсөл, арга хэмжээ ТЭЗҮ, ажлын даалгавар, зураг төсөвгүй байна.<sup>36</sup>

<sup>33</sup> 22.1.Энэ хуулийн 13.1.1, 13.1.2 дахь заалтыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

<sup>34</sup> 13.4.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно:

<sup>35</sup> 13.6.Иргэдээс санал авч дэмжигдсэн тохиолдолд Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, өрхийн амьжиргааг дэмжих болон иргэдэд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэхэд тоног төхөөрөмжийн болон арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн сургалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлж болно.

<sup>36</sup> 13.3.3.техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ.



2.8. Орон нутгийн хөгжлийн сангийн 2022, 2024 оны хөрөнгийн зарцуулалтад аудит хийгдээгүй тул аудитад хамруулсангүй.

2.9. Дээрх зөрчлүүдэд аудитаар аймаг, сумын ИТХ, Засаг дарга нарт зөвлөмж, албан шаардлагыг хүргүүлэн биелэлтийг тооцож байна.

2.10. Гэвч зөрчил арилахгүй байгаа нь хурлын төлөөлөгчид болон улс төрийн албан тушаалтнууд хуралдааны явцад санал гарган тогтоолд шинээр нэмж төсөл, арга хэмжээг тусгаж байгаагаас шалтгаалж байна.

#### Аудитын илрүүлэлт

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд 575.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 төсөл, арга хэмжээг, 2024 онд ТЭЗҮ, зураг төсөв, ажлын даалгаваргүй 50.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-аар баталсан;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд иргэд, олон нийтийн санал аваагүй 4,024.9 сая төгрөгийн 148 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр ИТХ-аар баталсан;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд ТЭЗҮ, ажлын даалгавар, зураг төсөвгүй 4,622.5 сая төгрөгийн 296 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр ИТХ-аар тус тус баталсан байна.

**Цахим худалдан авах ажиллагааг хуульд заасан журмын дагуу зохион байгуулахгүй байна.**

2.11. Говь-Алтай аймгийн хэмжээнд 2022-2024 онд цахим дэлгүүрээс 1,016.7 сая төгрөгийн 4588 бараа, үйлчилгээг худалдан авчээ.

2.12. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дахь хэсэгт<sup>37</sup> заасны дагуу цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авсан 2023 оны 326.4 сая төгрөгийн 18, 2024 оны 529.8 сая төгрөгийн 50 зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүлсэн байна.

2.13. Шийдвэрийн хэрэгжилтийн хувьд 2023 он 100.0 хувийн биелэлттэй, 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлэх хугацаа болоогүй байна.

2.14. Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авч буй зөрчил үүсэж буй нөхцөл байдлыг шалгагдагч этгээдээс тодруулахад байршуулсан бараа, үйлчилгээ гадуур зарагдаж буй ижил нэр төрлийн бүтээгдэхүүнээс үнэтэй, чанар муутай, шаардлага хангаж чаддаггүй гэсэн тайлбарыг өгч байна.

<sup>37</sup> 14.4.Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно.



- 2.15. Иймд цахим дэлгүүрийн бараа, үйлчилгээний сонголтыг нэмэгдүүлж, нийлүүлэгчийн чөлөөтэй өрсөлдөх боломжийг олгох зохицуулалтыг хийх шаардлагатай байна.
- 2.16. Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1<sup>38</sup>, 14.5<sup>39</sup> дахь хэсэгтэй холбоотой зөрчил аудитаар илрээгүй байна.

**Аудитын илрүүлэлт**

- Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авсан 856.3 сая төгрөгийн 68 зөрчил илэрсэн байна.

**БҮЛЭГ 3. ТӨРИЙН САНГИЙН НЭГДСЭН СИСТЕМЭЭР ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛСНААР ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАГДАХААР БАЙНА.**

**Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн зөрчил давтан гарсаар байна.**

- 3.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Энэ хуулийн хэрэгжилтэд төрийн аудитын байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллана” гэж заасан.
- 3.2. Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/59 дүгээр тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого чиглэл, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, А/89 дүгээр тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого чиглэлийг хэрэгжүүлэх зааврыг баримтлан хуулийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Санхүүгийн тайлангийн аудит, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит гүйцэтгэхдээ дээрх зааврыг баримтлан ажиллаж Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллаж байна.

*Хүснэгт №4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчил (сая төгрөг)*

Зөрчилд авсан арга хэмжээ	2022 он		2023 он		2024 он		Нийт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

<sup>38</sup> 14.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ

<sup>39</sup> 14.5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана.



Төлбөрийн акт	92	265.4	6	8.4	75	260.1	173	533.9
Албан шаардлага	187	739.9	51	858.5	177	2,658.1	415	4,256.5
Зөвлөмж	73	0	0	0	7	35.4	80	35.4
Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	0	0	0	0	0	0	0	0
<b>Нийт</b>	<b>352</b>	<b>1,005.3</b>	<b>57</b>	<b>866.9</b>	<b>259</b>	<b>2,953.6</b>	<b>668</b>	<b>4,825.8</b>

Эх сурвалж: Санхүүгийн тайлангийн аудитын 2022-2024 оны статистик мэдээ.

- 3.3. Хэрэгжилтийг авч үзвэл 2022 оны илэрсэн зөрчилд өгсөн шийдвэрийн хэрэгжилт 77.1 хувь, 2023 оны илэрсэн зөрчилд өгсөн шийдвэрийн хэрэгжилт 83.5 хувьтай байна.
- 3.4. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналтыг хэрэгжүүлээгүй байна.
- 3.5. Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2022-2024 онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд тусгайлан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналтыг хэрэгжүүлээгүй байна.<sup>40</sup>
- 3.6. Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс 2023 онд төсвийн байгууллагуудын зарлагын гүйлгээнд төрийн сангийн нэгдсэн системээр хяналтыг хэрэгжүүлэхэд 15.7 сая төгрөгийн 16, 0.8 сая төгрөгийн 4 гүйлгээг Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн үндэслэлээр буцаасан байна.<sup>41</sup>
- 3.7. Аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг 2022 онд 70.0 хувь, 2023 онд 100.0 хувь, 2024 онд 93.3 хувиар үнэлж, дээд шатны байгууллагаас үнэлгээг баталгаажуулсан байна.<sup>42</sup>

#### Аудитын илрүүлэлт

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хяналт шалгалт хийгээгүй байна.

**Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлснээр 2022-2024 онуудад байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын хүрээнд 3,093.0 сая төгрөгийн хэмнэлт бий болсон байна.**

- 3.8. Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлээр 2022 онд 51,650.4 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 44,508.1 сая төгрөгийг зарцуулж 86.2 хувийн, 2023 онд 63,492.9 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 56,171.5 сая төгрөгийг зарцуулж 88.5 хувийн, 2024 онд 95,867.2 сая төгрөгийг

<sup>40</sup> Говь-Алтай аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2025 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн 26 дугаар албан бичиг.

<sup>41</sup> Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 3/618 дугаар албан бичиг.

<sup>42</sup> <https://unelgee.gov.mn/>  
ЭУГ-2025/21-ШТА-НА



санхүүжүүлэхээр төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 76,355.1 сая төгрөгийг зарцуулж 79.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №5. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын төсвийн хэмнэлт (сая төгрөг)

Код	Үзүүлэлт	2022 он	2023 он	2024 он	Нийт дүн
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	278.0	656.5	2,041.4	<b>2,975.9</b>
210301	Гэрэл, цахилгаан	56.8	69.6	127.8	<b>254.3</b>
210302	Түлш, халаалт	176.3	540.9	1,694.2	<b>2,411.4</b>
210303	Цэвэр, бохир ус	44.9	46.0	206.5	<b>297.4</b>
210304	Байрны түрээс	-	-	12.8	<b>12.8</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	42.1	77.2	83.7	<b>203.0</b>
210401	Бичиг хэрэг	6.6	7.8	23.8	<b>38.2</b>
210402	Тээвэр, шатахуун	19.7	52.1	40.0	<b>111.8</b>
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11.3	9.1	8.3	<b>28.7</b>
210404	Ном, хэвлэл	3.4	6.4	4.0	<b>13.8</b>
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1.1	1.5	3.4	<b>6.0</b>
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	0.4	4.2	<b>4.6</b>
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	37.3	70.0	277.2	<b>384.4</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	16.8	16.1	50.2	<b>83.0</b>
210602	Тавилга	3.7	0.0	1.3	<b>5.0</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.0	-	-	<b>0.0</b>
210604	Урсгал засвар	16.8	53.9	225.7	<b>296.4</b>
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	17.0	40.1	49.5	<b>106.7</b>
210701	Гадаад албан томилолт	-	-	-	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	17.0	40.1	49.5	<b>106.7</b>
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-	-	<b>-</b>
<b>Нийт дүн</b>		<b>374.5</b>	<b>843.8</b>	<b>2,451.8</b>	<b>3,670.0</b>

Эх сурвалж: Орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022-2024 оны санхүүгийн аудитын тайлан.

3.9. Орон нутгийн төсвийн байгууллагуудын хувьд дутуу зарцуулалтаас зарим зардлыг 2022-2024 оны байдлаар түүвэрчлэн авч үзэхэд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2,975.9 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 203.0 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 384.4 сая төгрөгөөр, томилолт зочны зардлыг 106.7 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

3.10. Улсын төсвийн байгууллагуудын хувьд 2022 онд 90,488.9 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 84,962.6 сая төгрөгийг зарцуулж 93.9 хувийн, 2023 онд 117,578.2 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 107,291.1 сая төгрөгийг зарцуулж 91.3,



2024 онд 162,338.7 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 151,110.5 сая төгрөгийг зарцуулж, 93.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №6. Улсын төсвийн байгууллагуудын төсвийн хэмнэлт (сая төгрөг)

Код	Үзүүлэлт	2022 он	2023 он	2024 он	Нийт дүн
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>34.7</b>	<b>38.4</b>	<b>44.0</b>	<b>117.1</b>
210301	Гэрэл, цахилгаан	17.4	11.8	15.7	44.8
210302	Түлш, халаалт	12.3	21.8	23.1	57.1
210303	Цэвэр, бохир ус	5.0	4.9	5.2	15.1
210304	Байрны түрээс	0.0	0.0	0.0	0.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>126.7</b>	<b>144.9</b>	<b>134.3</b>	<b>405.9</b>
210401	Бичиг хэрэг	21.4	20.9	22.6	64.9
210402	Тээвэр, шатахуун	47.4	52.7	62.2	162.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17.4	13.3	16.7	47.3
210404	Ном, хэвлэл	3.8	0.8	3.1	7.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11.4	9.9	10.5	31.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25.4	47.3	19.2	91.9
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>288.4</b>	<b>92.5</b>	<b>70.1</b>	<b>451.1</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	148.7	37.1	25.0	210.8
210602	Тавилга	61.1	8.3	11.2	80.6
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4.5	0.0	0.8	5.2
210604	Урсгал засвар	74.1	47.1	33.2	154.5
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>27.0</b>	<b>24.5</b>	<b>38.3</b>	<b>89.8</b>
210701	Гадаад албан томилолт	0.0	0.0	0.0	0.0
210702	Дотоод албан томилолт	27.0	24.5	38.3	89.8
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.0	0.0	0.0	0.0
<b>Нийт дүн</b>		<b>476.8</b>	<b>300.4</b>	<b>286.7</b>	<b>1,063.9</b>

Эх сурвалж: Санхүүгийн тайлангийн аудитын 2022-2024 оны санхүүгийн аудитын тайлан.

3.11. Улсын төсвийн байгууллагуудын хувьд 2022-2024 оны байдлаар байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 117.1 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 405.9 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 451.1 сая төгрөгөөр, томилолт зочны зардлыг 89.8 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

3.12. Нийт 12 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс 2022 онд 6, 2023 онд 4, 2024 онд 6 нь ашигтай ажиллажээ.

Хүснэгт №7. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн цэвэр ашиг (сая төгрөг)

Д/д	Байгууллагын нэр	Цэвэр ашиг		
		2022 он	2023 он	2024 он



1	Алтай хотын тохижилт үйлчилгээний газар ААТҮГ	1,083.4	2,422.4	(1,021.5)
2	Суурин дулаан ОНӨААТҮГ	(66.8)	(30.4)	(30.4)
3	Алтай орон сууцны корпораци ААТҮГ	112.5	80.4	29.1
4	Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ	(93.5)	(30.8)	13.1
5	Ундарга Алтай ААТҮГ	314.4	131.7	206.1
6	Нийтлэг үйлчилгээ УТҮГ	(165.8)	7,051.8	(124.5)
7	Солонго дулаан ААТҮГ	(438.2)	(16.3)	49.9
8	Инноваци бизнес судалгааны газар ОНААТҮГ	37.1	(55.0)	(2.2)
9	Говь-Алтай “АЗЗА” ТӨҮГ	(36.2)	(49.5)	0.6
10	Алтай-Улиастай ЭХС ТӨҮГ		(4,158.5)	129.2
11	Говь-Алтай аймаг дахь Нисэх буудал	481.6	(892.5)	(773.2)
12	Радио телевизийн сүлжээний газар	695.0	(334.5)	(313.0)

Эх сурвалж: 2022-2024 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан.

**Албан тушаалтны хариуцлагагүй байдлаас шалтгаалан Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулахгүй байгаа зөрчил давтан гарсаар байна.**

- 3.13. Санхүүгийн тайлангийн 2022 оны аудитаар Шилэн дансны цахим системд 15,451.6 сая төгрөгийн 1008 гүйлгээг огт мэдээлээгүй, 480.5 сая төгрөгийн 55 гүйлгээг хугацаанд нь мэдээлээгүй зөрчил илэрсэн.
- 3.14. Илэрсэн зөрчилд төсвийн 42 шууд захирагч, 1 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, 1 төвлөрүүлэн захирагч, нийт 44 төсөв захирагчид зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.
- 3.15. Мөн Төсвийн 43 шууд захирагч, 2 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, 2 төвлөрүүлэн захирагч, нийт 47 төсөв захирагчид хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай зөвлөмж өгсөн.
- 3.16. Санхүүгийн тайлангийн 2023 оны аудитаар 19,715.6 сая төгрөгийн 14310 гүйлгээг огт мэдээлээгүй, 31,078.5 сая төгрөгийн 1184 гүйлгээг хугацаа хоцроон шилэн дансны цахим системд мэдээлсэн зөрчил илэрсэн.
- 3.17. Илэрсэн зөрчилд төсвийн 24 шууд захирагч, 2 төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд, 1 төвлөрүүлэн захирагч, нийт 27 төсвийн захирагчид зөрчил арилгах, төсвийн 2 шууд захирагчид хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.
- 3.18. Мөн төсвийн 26 шууд захирагч, 3 төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд, 1 төвлөрүүлэн захирагч, нийт 30 төсвийн захирагчид хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай зөвлөмж өгсөн.
- 3.19. Аудитаар өгсөн шийдвэрийн дагуу дутуу болон огт мэдээлээгүй зөрчлийг шилэн дансны цахим хуудсанд бүрэн нөхөн шивүүлж зөрчлийг арилгуулсан.



3.20. Шилэн дансны тухай хуулийн зөрчил нэмэгдсэн шалтгаан нь удирдлага, нягтлан бодогч солигдсон, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагуудын хяналт суларсан, нэгдсэн цахим хуудас шинэчлэгдсэнтэй холбоотой байна.

**Аудитын илрүүлэлт**

- Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулаагүй зөрчил 2023 онд өмнөх оноос 21.6 хувиар өссөн байна.



### ДҮГНЭЛТ:

**Аудитын нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:**

1. Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар нь орон тоо илүү ажиллуулах, хуульд заагаагүй шагнал урамшуулал, дэмжлэг олгох, бэлэг дурсгалын зүйл худалдах авч Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллахгүй байна.
2. Аймаг болон Цогт сумын Засаг дарга 2022-2024 онд 3 удаа Засаг даргын орлогч, зөвлөх томилон ажиллуулж 110.4 сая төгрөгийн цалин хөлс олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.
3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний 24.1 хувь нь иргэдээс санал аваагүй, 48.0 нь ТЭЗҮ, зураг төсөв, ажлын даалгаваргүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймаг, сумдын ИТХ-аар баталсан байна.
4. Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн автомашины 48.8 хувь тод дэвсгэр өнгө бүхий улсын дугааргүй байна.
5. Хяналт тавих чиг бүхий байгууллагуудын хяналт сул байгаагаас Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хязгаарлах, хориглох зардлыг төсвөөс зарцуулж буй зөрчил арилахгүй байна.
6. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг байршуулаагүй, хугацаа хоцроосон зөрчил давтан гарсаар байна.
7. Төрийн аудитын газраас хуулийн хэрэгжилтэд аудит хийж зөрчлийг арилгуулахаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг шалгагдагч байгууллагуудад нь хангаж ажиллахгүй байна.

### ШИЙДВЭР:

Аудитын дүгнэлтэд үндэслэн Үндэсний аудитын газарт 1 санал, аймаг, сумын ИТХ-д 1, Засаг даргад 3, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст 1 зөвлөмжийг хүргүүлээ.

#### **Үндэсний аудитын газарт санал:**

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бусад хууль тогтоомж, дүрэм, журамтай уялдсан, нарийвчилсан зохицуулалтуудыг тусгах саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх.

#### **Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх зөвлөмж:**

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр иргэд олон нийтээс санал авсан, хуульд заасан төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлах.

#### **Аймаг, сумын Засаг даргад хүргүүлэх зөвлөмж:**

- Төрийн аудитын байгууллагын өгсөн шийдвэрийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцож байх,



- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж санхүүгийн сахилга батыг дээшлүүлж, төсвийн хөрөнгийн зарцуулалтын ил тод байдлыг сайжруулах арга хэмжээг авах.
- Шинээр томилогдсон байгууллагын удирдах албан тушаалтан, санхүүгийн ажилтнуудын Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн сургалтыг цахимаар зохион байгуулан, албан хаагчдыг чадавхжуулах.

**Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал нарт хүргүүлэх зөвлөмж:**

- Төрийн аудитын байгууллагын өгсөн шийдвэрийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцож, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг авах.

**Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлэх зөвлөмж:**

- Төрийн сангийн удирдлагын цахим системээр дамжуулан зарлагын гүйлгээг хянахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хязгаарласан, хориглосон ажил гүйлгээг батлахгүй байх.



Монгол улс, Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум,  
Жинст баг, Төрийн аудитын байр-1402,  
Утас: +976 70483413,  
И-мэйл: [govialtai@audit.gov.mn](mailto:govialtai@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)